

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

#### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 4

Хуралдаан 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 14 цаг 20 минутад эхэлж, 15 цаг 45 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 25 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Үндэсний статистикийн хорооны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Үндэсний статистикийн хорооны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Төмөрчөдөрийн Гантөмөрийг томилуулахаар дүгнэлт гарган, нэр дэвшүүлж, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Үндэсний статистикийн хорооны Бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн</p>

		<p>албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Үндэсний статистикийн хорооны Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын газрын даргын албан тушаалд Баясгалангийн Ганбатыг томилуулахаар дүгнэлт гарган, нэр дэвшүүлж, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Үндэсний статистикийн хорооны Төрийн захиргааны удирдлагын газрын Мэдээлэл, сургалт, сурталчилгааны төвийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Үндэсний статистикийн хорооны Төрийн захиргааны удирдлагын газрын Мэдээлэл, сургалт, сурталчилгааны төвийн даргын албан тушаалд Аюушийн Дэмбэрэлийг томилуулахаар дүгнэлт гарган, нэр дэвшүүлж, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын Хүн ам, орон сууцны тооллогын товчооны даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар</p>

		сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын Хүн ам, орон сууцны тооллогын товчооны даргын албан тушаалд Авирмэдийн Амарбалыг томилуулахаар дүгнэлт гарган, нэр дэвшүүлж, Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
5	Хүний Эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр ажиллаж байсан Ж.Дашдоржийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 2001 оноос 2013 оны нэгдүгээр сар хүртэлх хугацаанд Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээр томилогдон ажиллаж байсан Жадамбын Дашдоржийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
6	Агентлагийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгийн 2013 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн ХЭГ/178 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Засгийн газрын тохируулагч агентлаг: 1. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга 2. Цөмийн энергийн газрын дарга 3. Стандартчилал, хэмжилзүйн газрын дарга Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг: 1. Газрын тосны газрын дарга 2. Хүүхдийн төлөө үндэсний

		<p>газрын дарга</p> <ol style="list-style-type: none"> <li>3. Худалдан авах ажиллагааны газрын дарга</li> <li>4. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга</li> <li>5. Мал эмнэлэг, үржлийн газрын дарга</li> <li>6. Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга</li> <li>7. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дарга</li> <li>8. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын</li> </ol> <p>албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу эдгээр албан тушаалд томилогдох удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 2013 оны хоёрдугаар сарын 8-ны өдрөөс эхлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, 2013 оны гуравдугаар сарын 3, 4-ний өдрүүдэд бүртгэн 7, 11, 12-ны өдөр сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар тогтов.</p>
7	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүлийн 2013 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/286 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу энэ албан тушаалд томилогдох удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 2013 оны хоёрдугаар сарын 8-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, гуравдугаар сарын 18, 19-ний өдрүүдэд бүртгэн, 21, 22-ны өдөр сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар</p>

		ТОГТОВ.
8	Улаанбаатар хотын ерөнхий менежерийн албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүлийн 2013 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/286 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу энэ албан тушаалд томилогдох удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 2013 оны хоёрдугаар сарын 8-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны гуравдугаар сарын 21, 22-ны өдөр зохион байгуулахаар тогтов.
9	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Баттулгын 2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/23 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу энэ албан тушаалд томилогдох удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 2013 оны хоёрдугаар сарын 8-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны гуравдугаар сарын 21, 22-ны өдөр зохион байгуулахаар тогтов.
	Бусад асуудал: • "Төрийн албаны зөвлөлийн	Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 4 дүгээр

	<p>хуралдааны дэг"-д өөрчлөлт оруулах тухай</p> <ul style="list-style-type: none"> <li>• "Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь"-т өөрчлөлт оруулах тухай</li> </ul>	<p>хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1.Төрийн албаны зөвлөлийн Хуралдааны дэгийг хавсралтаар шинэчлэн батлах.</p> <p>2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хуралдааны дэг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 26 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох.</p> <p>3.Хуралдааны дэгийг Зөвлөлийн гишүүд, Ажлын албаны холбогдох хүмүүст танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ажлын албаны дарга /С.Цэдэндамба/-д үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн дүрэм”-ийн “Дөрөв”-ийн 4.6-г үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн ажил, үүргийн хуваарийг хавсралтаар батлах.</p> <p>2. “Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 45 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	---	---

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

